



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/157-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Залруулсан алдаа .....	13
4.2 Төлбөрийн акт .....	13
4.3 Зөвлөмж.....	14

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА А.АРИУНАА ТАНАА

2022.02.21 № 20  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т  
Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,051,695.00	2,051,695.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,051,695.00	2,051,695.00
35100	Түүхий эд материал	1,759,330.00	1,786,875.00
35130	Эм боох материал	1,759,330.00	1,786,875.00
35400	Хангамжийн материал	292,365.00	264,820.00
35410	Бичиг хэргийн материал	84,185.00	152,920.00
35420	Аж ахуйн материал	208,180.00	111,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,008,551.99	57,900,930.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,008,551.99	57,900,930.03
39200	Биет хөрөнгө	14,008,551.99	48,900,930.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,070,000.00	31,570,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,070,000.00	-12,070,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	26,248,719.12	45,256,119.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,898,559.45	-20,485,745.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,190,114.29	8,006,514.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,531,721.97	-3,375,957.72
39300	Биет бус хөрөнгө	9,000,000.00	9,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,000,000.00	9,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	25,060,246.99	59,952,625.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	25,060,246.99	59,952,625.03
51	Засгийн газрын хувь оролцоо	25,060,246.99	59,952,625.03
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,000,000.00	9,000,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	16,060,246.99	50,952,625.03
51210	Өмнөх үеийн үр дүн	8,969,108.87	16,060,246.99
51220	Тайлант үеийн үр дүн	7,091,138.12	34,892,378.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	25,060,246.99	59,952,625.03

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	184,951,001.84	236,305,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,658,801.84	24,272,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,658,801.84	24,272,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,631,866.62	24,272,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,816,000.00	4,772,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	815,866.62	19,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,026,935.22	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,292,200.00	212,033,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	163,492,200.00	187,761,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163,492,200.00	187,761,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00	24,272,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800,000.00	21,731,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2,540,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	177,859,863.72	201,413,421.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,859,863.72	201,413,421.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	176,747,577.13	199,039,378.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,257,276.24	153,032,269.97
210101	Үндсэн цалин	77,960,402.66	83,422,986.25
210102	Нэмэгдэл	45,120,873.58	55,936,255.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,176,000.00	13,673,028.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,961,565.17	3,568,915.64
210201	Тэтгэврийн даатгал	1,366,800.00	1,148,915.25
210202	Тэтгэмжийн даатгал	183,630.00	60,536.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	122,500.00	44,228.90
210204	Ажилгүйдлийн даатгал	13,978.00	12,307.23
210205	Эрүүл мэндийн даатгал	2,274,657.17	2,302,928.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,830,000.00	12,636,689.23
210301	Гэрэл, цахилгаан	1,800,000.00	1,431,509.00
210302	Түлш, халаалт	10,230,000.00	10,230,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	975,180.23
2104	Хангамж, бараа материалын зардал	11,254,500.00	12,532,815.00
210401	Бичиг хэрэг	741,100.00	1,813,310.00
210402	Тээвэр, шатахуун	7,712,000.00	8,070,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,563,400.00	1,409,205.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	593,200.00	590,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,800.00	650,000.00
2105	Нормативт зардал	4,224,760.00	4,700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,706,060.00	4,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	545,700.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,700.00	450,000.00

Архангай аймгийн ШША-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	3,631,000.00	2,633,300.00
210702	Дотоод албан томилолт	3,631,000.00	2,633,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,291,112.00	3,053,967.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,683,500.00	2,591,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	297,832.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,500.00	138,375.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,752.00	22,000.00
210807	Газрын төлбөр	97,360.00	4,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,751,663.72	6,431,421.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,751,663.72	6,431,421.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,112,286.59	2,374,043.16
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,112,286.59	2,374,043.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,112,286.59	2,374,043.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,091,138.12	34,892,378.04
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,091,138.12	34,892,378.04

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,000,000.00	0.00	8,969,108.87	17,969,108.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,000,000.00	0.00	8,969,108.87	17,969,108.87
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	7,091,138.12	7,091,138.12
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,000,000.00	0.00	16,060,246.99	25,060,246.99
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,000,000.00	0.00	16,060,246.99	25,060,246.99
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,000,000.00	0.00	16,060,246.99	25,060,246.99
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	34,892,378.04	34,892,378.04
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,000,000.00	0.00	50,952,625.03	59,952,625.03

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	175,108,200.00	216,805,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,816,000.00	4,772,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,816,000.00	4,772,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,816,000.00	4,772,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,816,000.00	4,772,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,292,200.00	212,033,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	163,492,200.00	187,761,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163,492,200.00	187,761,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00	24,272,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800,000.00	21,731,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2,540,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,108,200.00	194,982,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,108,200.00	194,982,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	173,995,913.41	192,607,956.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,257,276.24	153,032,269.97
210101	Үндсэн цалин	77,960,402.66	83,422,986.25
210102	Нэмэгдэл	45,120,873.58	55,936,255.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,176,000.00	13,673,028.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,961,565.17	3,568,915.64
210201	Тэтгэврийн даатгал	1,366,800.00	1,148,915.25
210202	Тэтгэмжийн даатгал	183,630.00	60,536.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	122,500.00	44,228.90
210204	Ажилгүйдлийн даатгал	13,978.00	12,307.23
210205	Эрүүл мэндийн даатгал	2,274,657.17	2,302,928.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,830,000.00	12,636,689.23
210301	Гэрэл, цахилгаан	1,800,000.00	1,431,509.00
210302	Түлш, халаалт	10,230,000.00	10,230,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	975,180.23
2104	Хангамж, бараа материалын зардал	11,254,500.00	12,532,815.00
210401	Бичиг хэрэг	741,100.00	1,813,310.00
210402	Тээвэр, шатахуун	7,712,000.00	8,070,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,563,400.00	1,409,205.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	593,200.00	590,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,800.00	650,000.00
2105	Нормативт зардал	4,224,760.00	4,700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,706,060.00	4,700,000.00
210502	Хоол, хүнс	518,700.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	545,700.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,700.00	450,000.00
2107	Томиллолт, зочны зардал	3,631,000.00	2,633,300.00
210702	Дотоод албан томиллолт	3,631,000.00	2,633,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,291,112.00	3,053,967.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,683,500.00	2,591,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	297,832.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,500.00	138,375.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,752.00	22,000.00

Архангай аймгийн ШША-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	97,360.00	4,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,112,286.59	2,374,043.16
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,112,286.59	2,374,043.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,112,286.59	2,374,043.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	21,823,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	21,823,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	21,823,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	21,823,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	21,823,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-21,823,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,761,700.00	190,159,656.84	1,602,043.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,761,700.00	190,159,656.84	1,602,043.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,761,700.00	190,159,656.84	1,602,043.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	154,153,000.00	153,032,269.97	1,120,730.03
210101	Үндсэн цалин	83,634,700.00	83,422,986.25	211,713.75
210102	Нэмэгдэл	56,526,300.00	55,936,255.50	590,044.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,992,000.00	13,673,028.22	318,971.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,592,900.00	3,568,915.64	23,984.36
210201	Тэтгэврийн даатгал	1,480,000.00	1,148,915.25	331,084.75
210202	Тэтгэмжийн даатгал	160,000.00	60,536.12	99,463.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	127,000.00	44,228.90	82,771.10
210204	Ажилгүйдлийн даатгал	33,000.00	12,307.23	20,692.77
210205	Эрүүл мэндийн даатгал	1,792,900.00	2,302,928.14	-510,028.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,861,000.00	12,636,689.23	224,310.77
210301	Гэрэл, цахилгаан	1,800,000.00	1,431,509.00	368,491.00
210302	Түлш, халаалт	10,230,000.00	10,230,000.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	831,000.00	975,180.23	-144,180.23
2104	Хангамж, бараа материалын зардал	11,903,200.00	11,822,815.00	80,385.00
210401	Бичиг хэрэг	2,006,300.00	1,813,310.00	192,990.00
210402	Тээвэр, шатахуун	7,360,300.00	7,360,300.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,296,600.00	1,409,205.00	-112,605.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	590,000.00	590,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	650,000.00	0.00
2105	Нормативт зардал	4,700,000.00	4,700,000.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,700,000.00	4,700,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	450,000.00	450,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	450,000.00	0.00

**Архангай аймгийн ШША-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	2,633,300.00	2,633,300.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,633,300.00	2,633,300.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,468,300.00	1,315,667.00	152,633.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	853,300.00	853,300.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	297,832.00	2,168.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,000.00	138,375.00	26,625.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	22,000.00	28,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	4,160.00	95,840.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>191,761,700.00</b>	<b>190,159,656.84</b>	<b>1,602,043.16</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>187,761,700.00</b>	<b>185,387,656.84</b>	<b>2,374,043.16</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	187,761,700.00	185,387,656.84	2,374,043.16
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>4,000,000.00</b>	<b>4,772,000.00</b>	<b>-772,000.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	4,772,000.00	-772,000.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>0</b>
650002	Терийн тусгай албан хаагч (ТТ)	10	10	0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>24,272,100.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>24,272,100.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>24,272,100.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	710,000.00
210402	Тээвэр, шатахуун	710,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,130,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,130,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,432,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,432,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>24,272,100.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,272,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,731,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,540,300.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд бараа материалыг нэр төрөл тус бүрээр тайлан бэлтгэхтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 13<sup>А</sup>/20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулах, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлнэ”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 191.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 34.9 сая төгрөгөөр буюу 139 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Бараа материал	2.1	2.1	-	-
Үндсэн хөрөнгө	23.0	57.9	34.9	151.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>25.1</b>	<b>60.0</b>	<b>34.9</b>	<b>139.0</b>
<b>Өр төлбөр</b>	-	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	25.1	60.0	34.9	139.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>25.1</b>	<b>60.0</b>	<b>34.9</b>	<b>139.0</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 151.7 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 23.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 21.8 сая, шилжүүлэн авсан 19.5 сая, нийт 41.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 6.4 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 57.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 34.9 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163.5	187.7	24.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	1.8	24.3	22.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9.8	19.5	9.7
Төсөв байгууллагын өөрийн орлого	9.8	4.8	(5.0)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>184.9</b>	<b>236.3</b>	<b>51.4</b>
Цалин, шимтгэлийн зардал	137.2	156.6	19.4
Бусад бараа үйлчилгээний зардал	32.4	33.0	0.6
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4.3	3.0	(1.3)
Бараа үйлчилгээний бусад зардал	2.8	6.4	3.6
Урсгал шилжүүлэг	1.1	2.4	1.3
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>177.8</b>	<b>201.4</b>	<b>23.6</b>
<b>Үйл ажиллагааны нийт ур дун</b>	<b>7.1</b>	<b>34.9</b>	<b>27.8</b>

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал санхүүжилт өмнөх оноос 24.2 сая төгрөг буюу 14.8 хувиар өссөн нь орон тоо нэмэгдэж, цалингийн зардал өссөнтэй холбоотой байна. Урсгал санхүүжилтээс 1.6 сая төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 252.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх нийт 48.1 сая төгрөгөөр бууруулж, 203.9 сая төгрөгөөр хянаж баталжээ. Харин төсвийн тодотголоор дахин 12.1 сая төгрөгөөр бууруулж 191.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 191.8 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 187.7 сая төгрөгийн санхүүжилт авч төсөвт байгууллагын өөрийн орлогоор 4.8 сая төгрөг төвлөрүүлэн нийт 192.5 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 190.1 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж 2.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 1.6 сая төгрөг хэмнэсэн, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.8 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас Засаг даргын 2021 оны А/206 дугаар захирамжаар ковид цар тахалтай холбоотойгоор нэн шаардлагатай тоног төхөөрөмж авахад 6.4 сая төгрөг, мөн А/387 дугаар захирамжаар эзэнгүй цогцос оршуулах зардалд 2.0 сая төгрөг, аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зориулж аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын А/20 дугаар захирамжаар 4.8 сая төгрөг, мөн Эрдэнэбулган сумын ИТХ-ын 6 дугаар захирамжаар 4.0 сая төгрөг, Архангай аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шийдвэрийн дагуу аймгийн ИТХ-аас 4.6 сая төгрөг, байгууллагын өөрийн давсан орлогоос 2.5 сая төгрөг нийт 24.3 сая төгрөгийг төвлөрүүлж, тээвэр шатахууны зардалд 0.7 сая төгрөг, багаж техник хэрэгсэл худалдан авахад 7.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 16.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус байгууллагад ковид цар тахалтай холбоотойгоор нарийн мэргэжлийн шинжилгээ хийх тусгай тоног төхөөрөмж нэн шаардлагатай байгаа тухай хүсэлтийг аймгийн Засаг даргад тавьж нөөц сангаас 6.4 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 10 үндсэн зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 85.3 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 191.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 190.2 сая төгрөгийг зарцуулж, 99.2 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь шинжилгээний төлбөрийг өөрийн орлогоор төвлөрүүлдэг бөгөөд 2021 онд 4.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7.3 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 182.5 хувиар давуулан биелүүлжээ. Төлөвлөгөөнөөс давсан орлогоос 2.5 сая төгрөгийг Сангийн Сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны 217 дугаар тушаалаар зарцуулах эрхийг олгосон байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Суудлын автомашин ашиглалтын судалгаа: Тус байгууллага нь нийт 31.6 сая төгрөгийн анхны өртөг бүхий 3 автомашинтай, шатахууны зардалд 8.1 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 13.1 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан бөгөөд зөрчил илрээгүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн шинжилгээний алба нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 150 мэдээллээс бүх мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул аудитаас зөвлөмж өгөөгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар түлш халаалтын зардлын тооцоог нарийвчлан авч үзнэ.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 3.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, няравын тайлантай холбоотой зөрчилд зөвлөмж өглөө.

#### **4.1 Залруулсан алдаа**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт зарлага цэвэр зээлийн дүнгээс 2.4 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

#### **4.2 Төлбөрийн акт**

Түлш халаалтын зардлаас 2021 оны 12 дугаар сард нэхэмжилсэн дүнгээс 1258.9 мянган төгрөгөөр илүү тооцон шилжүүлж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй, илүү төлөлтийг санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол төсвийн хэмнэлтэд тооцохгүй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Бүх

хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг НББ-д заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Няравын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Няравын тайланг бараа материалын нэр төрөл тус бүрээр гаргахгүйгээр нэгтгэсэн байдлаар тайлагнасан байна. Энэ нь Сангийн Сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” -ын 3 дугаар зүйлийн 9-д “Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж, няравын тайланг загвар маягтын дагуу нэр төрөл, тоо хэмжээгээр бэлтгэж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
1	ШША	3	3.6	1	2.4	1	1.2	0	0	1	0
	Дүн	3	3.6	1	2.4	1	1.2	0	0	1	0
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
2	ШША	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Нийт дүн	3	3.6	1	2.4	1	1.2	0	0	1	0